



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/289

Номгон

Г 7

Төрийн болон орон нутгийн өмчийн эд
хөрөнгийн улсын үзлэг, тооллого
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5, 70 дугаар зүйлийн 70.4, Засгийн газрын Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах тухай 2025 оны 238 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогын ажлыг зохион байгуулах тухай 2026 оны 143 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогын ажлыг 2026 оны 06 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн зохион байгуулсугай.

2.Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг удирдан зохион байгуулах тооллогын салбар комиссыг хавсралтаар баталсугай.

3.Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажлыг удирдан зохион байгуулж, нэгдсэн удирдамж, аргачлалаар хангаж, тооллогын дүнг 2026 оны 07 дугаар сард багтаан хүлээн авч, 2026 оны 09 дүгээр сард Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт нэгтгүүлэхийг салбар комисс (Б.Наранбаяр)-т даалгасугай.


4.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2026 оны 143 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан журмын дагуу өөрийн эзэмшилд байгаа эд хөрөнгийг улсын үзлэг, тооллогод бүрэн хамруулах бэлтгэлийг хангаж, комисс томилон, Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн цахим системд улсын үзлэг, тооллогын ажлын үр дүнг оруулж, дүнг цахимаар тайлагнахад ашиглах, төрийн бусад төрөлжсөн мэдээллийн сангийн мэдээлэлтэй тулган, бүртгэлийг нягтлан шалгах, тулган баталгаажуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авч, тооллогын ажлыг 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдөр

620010797

багтаан гүйцэтгэж, удирдамж, зааврын дагуу тооллогын дүн, тайланг бэлтгэн Орон нутгийн өмчийн газар, тооллогын салбар комиссын төлөөлөгчид хүлээлгэн өгөхийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.


5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Отгонбаяр)-д даалгасугай.

ДАРГА



ЭНХБАТ

Аймгийн Засаг даргын 1096-оны 05 дугаар
сарын 15-ны өдрийн 1/2.89... дүгээр
захирамжийн хавсралт



ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН
УЛСЫН ҮЗЛЭГ, ТООЛЛОГЫН АЖЛЫГ УДИРДАН
ЗОХИОН БАЙГУУЛАХ САЛБАР КОМИССЫН
БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга:

Б.Наранбаяр

Аймгийн Засаг даргын орлогч

Комиссын орлогч дарга:

З.Мөнхтөр

Орон нутгийн өмчийн газрын даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд:

С.Байгалмаа

Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Т.Цэвээндорж

Цагдаагийн газрын дарга, цагдаагийн дэд
Хурандаа

С.Батцэрэн

Авто тээврийн төвийн дарга

Л.Аюурзана

Боловсролын газрын дарга

Г.Лхагва-очир

Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч

Б.Пүрэвдагва

Соёл урлаг, аялал жуулчлал, залуучууд
хөгжлийн газрын дарга

Ц.Мөнхжаргал

Улсын бүртгэлийн хэлтсийн дарга

С.Алтанцэцэг

Зохион байгуулалт, олон нийттэй харилцах
хэлтсийн дарга

А.Цэцэнбилэг

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын
газрын захиргаа удирдлагын хэлтсийн дарга

Даваабат

Төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий
нягтлан бодогч

Ш.Гэрэлсүх

Санхүү төрийн сангийн хэлтсийн Нягтлан
бодох бүртгэлийн мэргэжилтэн

М.Мөнхбат

Орон нутгийн өмчийн газрын удирдлага
төлөөлөл хариуцсан мэргэжилтэн

Б.Жаргалмаа	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын кадастрын мэргэжилтэн
Ө.Хандармаа	Хот байгуулалтын кадастр, Зураг төсөл, магадлалын асуудал хариуцсан мэргэжилтэн
Ц.Бямбасүрэн	Авто тээврийн төвийн улсын байцаагч
Б.Тэгшбаяр	Хөгжлийн бодлого, дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн
Л.Дуламсүрэн	Орон нутгийн өмчийн газрын нягтлан бодогч
Б.Төмөрбаатар	Орон нутгийн өмчийн газрын Хууль, хяналт шинжилгээ дотоод аудит хариуцсан мэргэжилтэн
М.Пүрэвдулам	Орон нутгийн өмчийн газрын Архив, бичиг хэргийн эрхлэгч
Нарийн бичгийн дарга: Т.Мөнхзул	Орон нутгийн өмчийн газрын Өмчийн удирдлага, хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн
А.Дорждулам	Орон нутгийн өмчийн газрын Өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан Мэргэжилтэн

_____оОо_____